



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

Байгууллагын нэр:

Газар зохион байгуулалт, геодези, зураг
зүйн газар

Нэгжийн нэр:

Геодези, зураг зүйн хэлтэс

Албан тушаалын нэр:

Геодези, зураг зүйн хэлтсийн дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Ахлах түшмэл, ТЗ-4

Ажлын цаг

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд солбицол өндрийн нэгдсэн тогтолцоонд бүх төрлийн геодезийн сүлжээ байгуулах, байр зүйн болон сэдэвчилсэн газрын зураг, газар зүйн нэрээр хангах, геодезийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, улсын хэмжээнд геодези, зураг зүйн үйл ажиллагааны нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Монгол Улсын хууль болон Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хэмжээний урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад геодези, зураг зүйн чиглэлээр санал өгөх, хэрэгжилтийг хангах, холбогдох хууль тогтоомж болон тэдгээрт нийцүүлэн гарах хэм хэмжээний акт, бусад баримт бичгийг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;


2.Монгол Улсын нутаг дэвсгэрт зохицсон байрлал, өндрийн нэгдсэн сүлжээ байгуулж зураглалын үндэслэлээр хангах, нутаг дэвсгэрийн хэлбэр хэмжээг тодорхойлох, жижиг, дунд, том масштабын газрын зураг, баталгаат газар зүйн нэрээр хангах, геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн сан, системийг байгуулж, олон нийтэд үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

3.Геодезийн хэмжил зүйн лабораторийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж геодезийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, багаж баталгаажуулах үйлчилгээг эрхлэх, бусад салбарт хэрэгжүүлж буй инженерийн геодезийн үйл ажиллагаанд хяналт тавих;

4.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн тайлан, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт геодези, зураг зүйн чиглэлээр хяналт, шинжилгээ үнэлгээ хийх, дүгнэлт өгөх, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах;

5.Олон улсын, салбар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах, салбарын үйл ажиллагааг сурталчлах, мэргэжлийн боловсон хүчний эрэлт хэрэгцээг тодорхойлох, байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах, мэргэшүүлэх, давтан сургах, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Монгол Улсын хууль болон Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад геодези, зураг зүйн чиглэлээр санал өгөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх;	Г
	2.Геодези, зураг зүйн чиглэлээр хийгдэх төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан, судалгаа, дүгнэлт бодитой хийгдсэн байх;	Г, Х
	3.Салбарын урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд геодези, зураг зүйн талаар тусах арга хэмжээг	Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан байх;	Г, Х



	боловсруулах, санал өгөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;		
	4.Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд геодези, зураг зүйн чиглэлийн арга хэмжээг боловсруулж, хэрэгжилтийг хангах;	Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан байх;	Г, Х
	5.Геодези, зураг зүйн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гарах хэм хэмжээний акт, геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ, үнийн индекс, норм, нормативын баримт бичиг, заавар, аргачлал боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх;	Г, Х
	6.Улсын төсөв, хөрөнгө оруулалтаар хийх геодези, зураг зүйн ажлыг төлөвлөх, техникийн төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, ажлын даалгавар боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	Геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөгөөттэй уялдсан ажил, үйлчилгээ хэрэгжсэн байх.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Монгол Улсын байрлал, өндөр, гравиметрийн нэгдсэн тогтолцоог боловсруулах, геодезийн тулгуур сүлжээний солбицол, өндөр, хүндийн хүчний хурдатгалын утга, солбицол, өндөр, хүндийн хүчний тогтолцооны эрин хоорондын хурдны утгыг тогтоох, батлуулах, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;	Бүх төрлийн сүлжээний нарийвчлал сайжирсан, мэдээллийн сан бүрдсэн, түүгээр үйлчилгээ үзүүлсэн байх;	Г, Х
	2.Монгол Улсын геодезийн байрлал, өндөр, гравиметрийн тулгуур сүлжээ байгуулах, шинэчлэх, өтгөрүүлэх, нарийвчлалыг сайжруулах, геодезийн байнгын цэг тэмдэгт байгуулах, цэг тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого, үнэлгээ, мониторинг хийх ажлыг зохион байгуулах;	Бүх төрлийн сүлжээний нарийвчлал сайжирсан, мэдээллийн сан бүрдсэн, түүгээр үйлчилгээ үзүүлсэн байх;	Г, Х
	3.Улсын хэмжээнд Байнгын ажиллагаатай суурин станц /GNSS/-ыг байгуулах, шинэчлэх, өтгөрүүлэх, хэвийн ажиллагааг хангах ажлыг зохион байгуулах;	Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн Геодези, зураг зүйн чиглэлээрх ажлыг улсын нэгдсэн санд хүлээн авсан байх;	Г, Х
	4.Монгол орны нутаг дэвсгэрийг агаар, сансрын зургаар хангах ажлыг зохион байгуулах;	Нийт нутаг дэвсгэр агаар сансрын зургаар хангагдсан байх;	Г, Х
	5.Монгол Улсын нутаг дэвсгэрийг том, дунд, жижиг масштабын байр зүйн зургаар зурагжуулах, шинэчлэх, усны	Нийт нутаг дэвсгэр зурагжуулагдсан байх;	Г, Х



гүний хэмжилт, зураглалын ажлыг зохион байгуулах;		
6.Сургалт, нийтийн хэрэгцээний сэдэвчилсэн газрын зураг, атлас, үндэсний атлас зохиох, шинэчлэх, хэвлүүлэх, хэрэглээнд гаргах батлагдсан нэг маягийн сууриар хангах ажлыг зохион байгуулах;	Хэрэглэгчид газрын зураг атласаар хангагдсан байх;	Г, Х
7.Монгол орны газар зүйн нэрийг тодотгон тогтоох, Газар зүйн нэрийн толийг баяжуулах, орон нутгийн иргэдийг үнэн, зөв, баталгаажсан газар зүйн нэрээр нэрлэж сургах, хэвшүүлэх, шинэ нэр, өөрчлөгдсөн нэрийг батлуулах ажлыг зохион байгуулах;	МУ-ын нутаг дэвсгэр дээрх газар зүйн нэрийг тодотгон тогтоосон, баталгаажуулсан байх;	Г, Х
8.Улсын хэмжээнд хийгдэх инженер геодезийн хэмжилт, зураглалын ажлыг зохион байгуулах;	Газар дээрх болон газар доорх инженер геодезийн хэмжил зураглалын ажил хийгдсэн байх;	Г, Х
9.Монгол Улсын хилийг солбицолжуулах, тэмдэгжүүлэх, зурагжуулах, Монгол улсын нутаг дэвсгэрийн газрын сан нэгдмэл байх нөхцлийг геодезийн хэмжил зүйгээр баталгаажуулах ажлыг зохион байгуулах;	Улсын болон аймаг сумын хилийн солбицолжуулж, баталгаажуулсан байх;	Г, Х
10.Геодези, зураг зүйн чиглэлээр хийгдсэн ажил технологи, нарийвчлалын шаардлага хангаж буй эсэхийг шалгаж, акт үйлдэх, Геодези, зураг зүйн нэгдсэн сан хөмрөг болон мэдээллийн санд хүлээлгэн өгөх, мэдээ, тайлан гаргах;	Улсын төсвөөр хийгдэж буй ажлууд шалгагдсан, улсын нэгдсэн санд хүлээлгэж бүртгэгдсэн байх;	Г, Х
11.Зайнаас тандан судлалын аргаар орон зайн мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл, мэдээллийг шинэчлэх ажлыг зохион байгуулах;	Орон зайн өгөгдөл, мэдээлэл шинэчлэгдсэн байх;	Г, Х
12.Улсын хэмжээнд геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;	Мэдээллийн сангийн шаардлагыг хангасан байх;	Г, Х
13.Геодези, зураг зүйн мэдээллийн систем байгуулах санал боловсруулах, хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;	Холбогдох журмын дагуу үйлчилгээнд гаргасан байх;	Г, Х



	14.Тусгай болон нийтийн зориулалттай байр зүйн зураг зохиох, хэрэглээнд гаргах ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомж, стандарт, норм дүрэмд нийцсэн байх;	Г, Х
	15.Олон улсын геодезийн хэмжилтэд оролцох, магадлан хэмжилт хийх ажлыг зохион байгуулах.	Холбогдох хууль тогтоомж, стандарт, норм дүрэмд нийцсэн байх.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Геодезийн хэмжих хэрэгсэлд шалгалт, тохиргоо, баталгаажуулалт хийх, баталгаажуулалтын гэрчилгээ олгох, хэмжлийн багаж хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд хяналт тавих, дүгнэлт зөвлөмж гаргах, үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;	Олон улсын болон үндэсний стандарт, шаардлагад нийцсэн байх;	Г, Х
	2.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын болон геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн багаж баталгаажуулалтад хяналт тавих, дүгнэлт гарган, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх;	Г, Х
	3.Хэмжил зүйн лабораторийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, геодезийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх;	Г, Х
	4.Лабораторийн үйл ажиллагаанд дотоод аудитын хяналт, шалгалт хийх, дотоод болон гадаад аудитын шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх;	Г, Х
	5.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн багажийг баталгаажуулах үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлэх, багажийн бүртгэлийн мэдээллийн сан хөтлөх;	Төрийн үйлчилгээний стандарт шаардлагад нийцсэн байх;	Г, Х
	6.Геодезийн хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийн нарийвчлалыг холбогдох байгууллагатай хамтран турших, үр дүнг батлуулах ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомж, стандарт, норм дүрэмд нийцсэн байх;	Г, Х
	7.Улсын хэмжээнд хийгдэх инженер геодезийн хэмжилт, зураглалын ажилд хяналт тавих.	Инженер геодезийн ажил Засгийн газрын баталсан солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд	Г, Х



		хийгдсэн байх.	
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;	Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан байх;	Г, Х
	2.Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар батлуулан хэрэгжүүлж, тайлагнах, танилцуулах ажлыг зохион байгуулах;	Холбогдох журамд нийцсэн байх;	Г, Х
	3.Нэгжийн ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлэх;	Холбогдох журамд нийцсэн байх;	Г
	4.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд геодези, зураг зүйн талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, хэрэгжилтийг хангах;	Хууль тогтоомжийн хүрээнд санал боловсруулагдсан байх;	Г
	5.Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоог гаргаж төсөвт тусгуулах;	Тооцоо, судалгааг нь үнэн зөв гаргасан байх;	Г, Х
	6.Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажилд Захиалагчийн нэрийн өмнөөс хяналт шалгалт хийх, акт үйлдэх, геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд төвлөрүүлэх;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх;	Г, Х
	7.Бүх төрлийн сэдэвчилсэн газрын зураг, атласын зохиолтын эхэд мэргэжлийн дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх;	Г, Х
	8.Гадаад улсын зохиож, хэвлэсэн, олон нийтийн сүлжээнд нийтэлсэн газрын зураг, атлас, сурах бичиг, сэтгүүл, ном, товхимол, илтгэлд тусгагдаж байгаа Монгол Улсын газрын зураг, газар зүйн оноосон нэрийг зөв хэрэглэж байгаа эсэхийг хянах, шалгах, залруулга хийлгэх ажлыг зохион байгуулах.	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх.	Г, Х
5 дугаар зорилтын хүрээнд	1.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;	Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй хэвийн явагдсан байх;	Г



2.Геодези, зураг зүйн чиглэлээр олон улсын, салбар, байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, ажлыг зохион байгуулах;	Холбогдох тогтоомжтой нийцсэн байх;	хууль	Г
3.Геодези, зураг зүйн чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Холбогдох тогтоомжтой нийцсэн байх;	хууль	Г
4.Геодези, зураг зүй, багаж баталгаажуулалтын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;	Судалгаа, бодитой хийгдсэн байх;	дүгнэлт	Г
5.Улсын хэмжээнд геодези, зураг зүйн чиглэлээр хийгдсэн судалгаа, хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, хууль, тогтоомжийн хэрэгжилт, зохион байгуулсан арга хэмжээ, хүрсэн үр дүн, мэдээллийн сангийн талаар олон нийтэд сурталчилах, кино, үзэсгэлэн, сэтгүүл, товхимол гаргах ажлыг зохион байгуулах;	Олон нийтийг бодитой мэдээллээр хангасан байх;	зөв,	Г
6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний нэгжийн үйл ажиллагаанд хамаарах ажлыг зохион байгуулах, үнэлгээний хороо болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах;	Холбогдох тогтоомжтой нийцсэн байх;	хууль	Г
7.Байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хурал, удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, цаг үеийн шаардлагаар гарсан ажлуудыг тухай бүр зохицуулан зохион байгуулах, биелэлтийг хангах;	Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байх;		Г
8.Байгууллагын дотоод дүрэм, журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллах, төрийн захиргааны манлайллыг хэрэгжүүлэх;	Дүрэм, журам ёс зүйн хэм хэмжээнд заасан манлайлал бий болсон байх;		Г
9.Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах;	Архивын үндсэн нийцсэн байх;	ажлын зааварт	Г
10.Геодези, зураг зүйн салбарын боловсон хүчний эрэлт хэрэгцээг	Салбарын мэргэжилтнүүдийн		Г



	тодорхойлох, сургалтын төлөвлөгөөнд санал өгөх, хүний нөөцийг чадавхижуулах, мэргэшүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулах;	мэргэжлийн чадавхи дээшилсэн байх;	
	11.Геодези, зураг зүйн орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, туршлага судлах ажлыг зохион байгуулах;	Судалгаа, дүгнэлт бодитой хийгдсэн байх;	Г
	12.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага болон бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах.	Бусад салбар геодези, зураг зүйн чиглэлээр ойлголт мэдлэгтэй болсон байх.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	Дэлхий судлал (053201) (геодезийн инженер, инженер геодези, сансрын геодези-астрономи, агаарын зураглал, зураг зүй).		
Мэргэшил	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
Туршлага	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- Нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх, зарчимч шаардлага тавих; - нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх; - албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, зохих заавар чиглэл өгөх; - асуудлыг шийдвэрлэхдээ түүний эерэг, сөрөг үр дагаврыг тооцох; - аливаа асуудлыг шийдвэрлэхдээ тухайн асуудалд хамаарал бүхий бүх талууд (байгууллагын дотор болон гадна)-ын оролцоог хангадаг байх; - аливаа асуудлыг шийдвэрлэхдээ хамт олны саналыг харгалзан үздэг байх; - албан хаагчдын саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.	
	Дүн шинжилгээ хийх	- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; - нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг нэгтгэн дүгнэх, санал зөвлөмж боловсруулах; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;	



		- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх, тоон судалгаанд үндэслэн харьцуулалт, шинжилгээ хийх; - тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдал, хувилбарыг тодорхойлох чадвартай байх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- Албан тушаалын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг боловсруулах; - удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах; - хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, мэдээлэлтэй холбогдсон асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах; - бусад.
	Манлайлах	- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих, үр дүнтэй өөрчлөлт, шинэтгэлийг дэмжин хэрэгжүүлдэг байх; - багаар ажиллах, багийн ажлын амжилтыг үнэлэх, дэмжих, үүрэг хариуцлага хүлээх чадвартай байх; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах, хөрвөх чадвартай байх; - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; - ёс зүй, хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд бусдыг үлгэрлэн манлайлах; - бусад.
	Бусад ур чадвар	- Нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх, зарчимч шаардлага тавих; - нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх; - албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, зохих заавар чиглэл өгөх; - асуудлыг шийдвэрлэхдээ түүний эерэг, сөрөг үр дагаврыг тооцох; - аливаа асуудлыг шийдвэрлэхдээ тухайн асуудалд хамаарал бүхий бүх талууд (байгууллагын дотор болон гадна)-ын оролцоог хангадаг байх; - аливаа асуудлыг шийдвэрлэхдээ хамт олны саналыг харгалзан үздэг байх; - албан хаагчдын саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Геодези, орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газрын дарга.



